

БАТЛАВ
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА 
Б.БЯМБАСҮРЭН

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 06 сарын 24

Хүрээмдэрал

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Орлоготой иргэн

1.1.1 Гарааны бизнес эрхлэгчид өрхийн орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих

1.2 Эрүүл иргэн

1.2.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны "Жишиг загвар төв" байгуулах, Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, эмнэлгийн оношилгоо, мэдээллийг цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлэх, "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлж, "Элэг бүтэн Баянхонгор" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.2 Бүх иргэдээ эрүүл мэндийн нэгдсэн үзлэг оношилгоонд хамруулж хүний эрүүл мэндийн нэгдсэн сантай болно.

1.2.3 Аймаг улс руу чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний чирэгдлийг багасгаж Хүрээмдэрал суманд гэмтлийн түргэн тусlamжийн нэгж байгуулна.

1.2.4 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлэн эмч мэргэжилтнийг нарийн мэргэжлээр мэргшүүлж иргэн бүр эрүүл мэндийн үзлэгт жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.

1.2.5 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, орон нутгийн оношилгоо мэдээллийг дээд шатны эмнэлгүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

1.2.6 Эрүүл мэндийн төвийг орчин үеийн шаардлагатай тоног төхөөрөмжээр бүрэн хангах.

1.2.7 Багийн эмч нарыг хөдөөгийн айл өрхөөр оруулж малчдын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог сайжруулна.

1.3 Чанартай боловсрол

1.3.1 Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ



000000001

9
БАТЛАВ

1.3.2 Хүрээмжилсэн 90 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварыг хийж ашиглан яслийн бүлэгтэй болж, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэн орчны стандартыг хангана.

1.3.3 Хүүхдийн тоглоомын талбайг шинэчлэн тоглоомоор хангана

1.3.4 Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулж, удирдлага мэдээллийн шинэчлэл хэрэгжүүлнэ.

1.3.5 Багшийн хөгжил ур чадварыг үнэлэх, хүүхдэд эзэмшүүлсэн мэдлэг чадварын үнэлгээгээр багшийг урамшуулах баримт бичгийг боловсруулан сайн багшийг мэргэжилдээ өсөх хөгжих, туршлага судлахад бүх талын дэмжлэг үзүүлнэ.

1.3.6 Хүүхдийн хөгжих, нийгэмших, харилцаа ёс суртахууны хувьд төлөвших нөхцөлд зэрэг нөлөө үзүүлэх орчин г бий болгож соён гэгээрүүлэх чиглэлийн хичээл сургалтыг тогтмол оруулна.

1.3.7 Ерөнхий боловсролын сургуульд бага сургууль шинээр барих.

1.3.8 Хүүхэд залуусын спорт хөгжлийн төв, спортын төрлүүдийн гадна талбайтай болно

1.3.9 Сургалтад шаардагдах тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангах

1.4 Тогтвортой - Амар амгалан гэр бүл

1.4.1 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

1.4.2 Улаанбаатар хотод мэргэжил эзэмшсэн эзэмшиж буй иргэдийн мэдээллийн санг бүрдүүлж, тэдний орон нутагтаа хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ

1.4.3 Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.4.4 Залуу гэр бүлийг цаашид тогтвортой суурьшилтай амьдрах өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд бодит арга хэмжээ авна.

1.5 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр

1.5.1 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.5.2 Хүүхдийн хүчирхийлэл осол гэмтлээс хамгаалах олон талт арга хэмжээг зохион байгуулах.

1.5.3 Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, гудамж талбайг гэрэлтүүлэх, камержуулэх.

1.5.4 Хүүхдийг сонирхлынх нь дагуу гүнзгийрүүлсэн сургалтад хамруулж мэргэшүүлэх ажлыг тогтмолжуулна.

Залуучуудыг дэмжих чиглэлээр



1.5.5 Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.5.6 Соёл урлаг, биеийн тамирын чиглэлээр залуучуудыг хөтөлбөр боловсруулан дэмжиж ажиллана.

Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дэмжих

1.5.7 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

1.5.8 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулан хөнгөлөлт эдлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэхэд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5.9 Ахмад настны амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжих төвийг байгуулан Ахмадын холбооны үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

Үндэсний баархал, өв соёл, спорт

1.5.10 Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулж дэмжлэг үзүүлнэ.

1.5.11 Нийтийн бие тамирыг хөгжүүлж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх.

1.5.12 Шинэ соёлын төвийг тоног төхөөрөмжөөр хангаж гадна тохижилтыг хийхэд дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. “Тунгалаг санхүү” хөтөлбөр, “Хуримтлалтай Хүрээмаралчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2 Барилгын блок тоосго материал үйлдвэрлэх, арьс шир боловсруулах, сүү зүүн бүтээгдэхүүн боловсруулах, оёдлын үйлдвэр зэрэг жижиг үйлдвэрүүдийг байгуулна.

2.3 Засаг даргын тамгын газрын хуучин барилгыг ахуйн үйлчилгээний зориулалтаар ашиглана.

Төрөлжсөн аялал жуулчлал

2.4 Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бизнесийг хэрэгжүүлж Хүрээмчандал хайрханы энергийн төвийг байгуулж аялал жуулчлалын цогцолбор байгуулна.

2.5 Баянхонгор аймгаас Говь-Алтай аймгийн чиглэлийн аяллын маршрутыг утгаж төв зам дагуу зочлох үйлчилгээний стандарт хангасан зочид буудал, зоогийн газар болно.

Дэд бүтэц




• 000000003

2.6 Сумын төвийн гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохирын шугам сүлжээнд холбож орчны бохирдлыг бууруулна.

2.7 “Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж, сумын төвийн айл өрхийг инженерийн шугам сүлжээгээр холбож, гудамж хорооллын замын гэрэлтүүлгийг сайжруулна.

2.8 Хүүхэд залуучуудын чөлөөт цагаан зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

2.9 Гэр хорооллын айл өрхийг био жорлонгоор хангаж, хөрсний бохирдлыг бууруулна.

2.10 Сонор 2 дугаар баг, Норовлин 3 дугаар багийн алслагдсан нутагт үүрэн телефоны дахин дамжуулах станц байрлуулах.

2.11 Нисэх онгоцны аэродром байгуулах.

2.12 Нутгийн удирдлагын ордон шинээр барьж ашиглалтад оруулах.

2.13 Сумын төвийн тоосжилтыг бууруулж 2 км авто замыг барих.

ГУРАВ .ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1 өлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”ийг батлуулан хэрэгжүүлж, “Орон сууц хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулах,

3.2 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлэх, Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна

3.3 Багуудын төвийг тохижуулж байнгын ажиллагаатай болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4 Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлж ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллахыг хэвшүүлнэ.

3.5 Сумын цагдаа, хэсгийн төлөөлөгчийн ажлыг дэмжиж ажиллана.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО


4.1 Усны нөөц, голуудын урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авна

4.2. Сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

4.3. “Хашаандаа сайхан амьдаръя” төслийг хэрэгжүүлж хашаандаа хүнсний ногоо тариалахыг бодлогоор дэмжинэ.

ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХҮЙ

5.1. Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх “Илгээлтийн эзэн-III” аяныг хэрэгжүүлнэ




000000002

5.2 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлж, чанар, ашиг шимиийг сайжруулах ажлыг эрчимжүүлнэ

5.3 Малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулж, малын генийн санг хамгаалан биотехнологийн ололтыг нэвтрүүлэх,

5.4 Махны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор мах, сүүний чиглэлийн мал үргүүлэх бүс нутгуудын малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрч, "Эрүүл бүс" нутагт тавигддаг олон улсын шаардлагуудыг хангаж зах зээлд зарлана.

5.5 Хүрээмарал сумын тариалалтын талбайд малын тэжээлийн ургамал тариалах ажлыг дэмжинэ.

5.6 Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг жил бүр зохион байгуулж дархлалтыг бууруулна.

5.7 Бэлчээрийг зохистой ашиглах, малын тоо толгойг зохист түвшинд барих, мал махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого гаргаж "Бэлчээр ашиглалтын журам"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

5.8 Худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.

5.9 Малчдыг хадлан, гэр тэжээл бэлтгэх тоног төхөөрөмжөөр хангаж нөөц бүрдүүлэхэд.

ооо

A handwritten signature is written over a red circular stamp. The stamp contains the text 'МОНГОЛ УИХНЫ ААНЫ САХААТЫН НАДАГ' (Mongolian State Great Seal) in a stylized font.

000000005